



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 08 өдөр


Дугаар 8/26

Улаанбаатар хот


Г Аргачлал батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Аймаг, нийспэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн нэгдсэн бодлогын газар /Л.Балчинлувсан/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү аргачлалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



230130



АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулах болон холбогдох нутгийн захиргааны байгууллага нь (цаашид “холбогдох байгууллага” гэх) Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналаа нэгтгэн боловсруулахад энэхүү аргачлалыг баримтална.

1.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар (цаашид “Аймаг, нийслэлийн ЗДТГ”) нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актад үндэслэнэ.

- 1.3. Энэ аргачлалд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:
- 1.3.1. “салбарын үр дүн” гэж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний боловсруулах аргачлалын 1.4.2-т тодорхойлсныг;
 - 1.3.2. “төсвийн ерөнхийлөн захирагч (цаашид “ТЕЗ” гэх)-ийн үр дүн” гэж салбарын үр дүнг хангах төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний үндсэн үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;
 - 1.3.3. “хөтөлбөрийн үр дүн” гэж төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг хангах хөтөлбөр хэрэгжсэнээр бий болох эерэг өөрчлөлтийг;
 - 1.3.4. “хөтөлбөр” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.16-д тодорхойлсныг;
 - 1.3.5. “үндсэн үйл ажиллагаа” гэж төрийн байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагчийн мандатыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай багц арга хэмжээг;
 - 1.3.6. “төсөл” гэж хөтөлбөрийн үр дүн гарахад хувь нэмэр оруулахаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт эсвэл нэг удаагийн багц арга хэмжээг;
 - 1.3.7. “арга хэмжээ” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.17-д тодорхойлсныг.

1.4. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг энэхүү аргачлалын хоёрдугаар хавсралтад заасан загварын дагуу, гуравдугаар хавсралтад заасан цаглаврын дагуу боловсруулна.

1.5. Холбогдох байгууллага нь энэхүү аргачлалын дөрөвдүгээр хавсралтад заасан загварын дагуу Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгуулах саналаа Аймаг, нийслэлийн ЗДТГ -т хүргүүлнэ.

1.6. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах чиг үүргийг Аймаг, нийслэлийн ЗДТГ хэрэгжүүлэх ба ажлын төлөвлөгөөг тухайн шатны Засаг даргаар батлуулна.

1.7. Аймаг, нийслэлийн ЗДТГ нь өмнөх оны Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар санал, зөвлөмжтэй танилцаж төлөвлөгөө боловсруулахдаа тусгана.

1.8. Аймаг, нийслэлийн ЗДТГ нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар санал, зөвлөмж боловсруулж оролцогч талуудад нэгдсэн байдлаар хүргүүлнэ.

Хоёр. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх

2.1. Аймаг, нийслэлийн ЗДТГ нь тухайн аймаг, нийслэл, хотын хэмжээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийнэ. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх хүрээнд дараах мэдээллийг цуглувна.

2.1.1. Өмнөх жилийн аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний урьдчилсан гүйцэтгэл;

2.1.2. Улс, бүс, орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хүний хөгжил, засаглалын үндсэн үзүүлэлтүүд, тэдгээрийн урьдчилсан гүйцэтгэл болон дунд хугацааны таамаглал;

2.2. Аймаг, нийслэлийн ЗДТГ нь энэхүү аргачлалын 2.1 дэх хэсэгт заасан мэдээ, мэдээлэл, өгөгдэл дүн шинжилгээ хийж, ирэх жилийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд нөлөөлөх шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж, үнэлэн, эрсдэлийг удирдах арга замыг тодорхойлсон эрсдэлийн суурь судалгааг боловсруулан, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний танилцуулгад хавсаргана.

2.3. Холбогдох байгууллага нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэгтгэн боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээг дараах мэдээлэлд тулгуурлан хийнэ.

2.3.1. Мандатын шинжилгээ;

2.3.2. Дотоод, гадаад орчны шинжилгээ;

2.3.3. Шаардлагатай тохиолдолд Аймаг, нийслэлийн засаг даргын болон хөтөлбөрийн үр дүн болон хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх арга замыг шинээр тодорхойлох, орчны шинжилгээгээр тогтоогдсон сул тал, эрсдэлийг арилгах төлөвлөгөө;

2.3.4. Стратеги төлөвлөгөөний үр дүнгийн шинжилгээ;

2.3.5. Жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгийн шинжилгээ.

Гурав. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх үр дүн, үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг төлөвлөх

3.1. Тухайн жилийн Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон нэхцэл байдлын дүн шинжилгээ, холбогдох байгууллагаас Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналд үндэслэн энэхүү аргачлалын хоёрдугаар хавсралтын нэгдүгээр хүснэгтийн дагуу Аймаг, нийслэлийн ЗДТГ боловсруулна.

3.2. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх үр дүнг Салбарын, Төсвийн ерөнхийлөн захирагчийн (Аймаг, нийслэлийн Засаг даргын), Хөтөлбөрийн гэсэн турван түвшнээр ялгаж хооронд нь уялдуулан төлөвлөнө.

3.3. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг энэхүү аргачлалын хоёрдугаар хавсралтын нэгдүгээр хүснэгтийн дагуу дараах байдлаар төлөвлөнө.

3.3.1. "Салбарын үр дүн" баганад Хөгжлийн бодлогын баримт бичигт үндэслэсэн Салбарын үр дүнг бичнэ.

3.3.2. "Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн" баганад Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтод үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг тодорхойлж бичнэ.

3.3.3. "Хөтөлбөрийн үр дүн" баганад тухайн шатны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэн Хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж бичнэ.

3.3.4. "Бодлогын үндэслэл" баганад үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний үндэслэлийг ЗДУАХ, ЗДУАХХАХТ-ний холбогдох дугаарыг бичнэ.

3.3.5. "Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ" баганад Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний хөтөлбөрийн үр дүн тус бүрээр төлөвлөнө.

3.3.6. "Шалгуур үзүүлэлт", "Хэмжих нэгж", "Мэдээллийн үзүүлэлтүүд" баганад Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, мэдээллийн үзүүлэлтүүдийг оновчтой тодорхойлж бичнэ.

3.3.7."Санхүүжилт" баганад үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэрийг оруулж өгнө. Санхүүжилтийн эх үүсвэрийг дараах жагсаалтаас сонгож оруулна.

3.3.7.1. Улсын төсөв

3.3.7.2. Орон нутгийн төсөв

3.3.7.3. Гадаадын зээл

3.4.7.4. Тусlamж

3.3.7.5. Бусад эх үүсвэр

3.3.8."Хариуцагч" баганад үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний үндсэн хариуцагчаас эхлэн хамтран хариуцагчийг тодорхойлж бичнэ.

**Дөрөв. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний
үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт,
зорилтот түвшинг тодорхойлох**

4.1. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг энэхүү аргачлалын хоёрдугаар хавсралтын хоёрдугаар хүснэгтийн дагуу дараах байдлаар төлөвлөнө.

4.2. “Бодлогын үндэслэл” баганад салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүнд хамаарах дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын дугаарыг бичнэ.


4.3. “Үр дүн” баганад Хүснэгт 1 -д тодорхойлсон салбар, ТЕЗ, хөтөлбөрийн үр дүнг хуулж бичнэ.

4.4. “Шалгуур үзүүлэлт”, “Хэмжих нэгж” баганад үр дүнг хэмжих хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тодорхойлж бичнэ.

4.5. “Суурь түвшин” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, урьдчилсан гүйцэтгэлийн хүрсэн түвшинд үндэслэн суурь түвшнийг тодорхойлж бичнэ.

4.6. “Зорилтот түвшин” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, суурь түвшинд үндэслэн зорилтот түвшнийг тодорхойлж бичнэ.

4.7. “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүнгийн мэдээллийн бэлэн байдлыг өгөгдсөн үзүүлэлтүүдийн дагуу тодорхойлж бичнэ.



Монгол Улсын Шадар сайд бөгөөд
Эдийн засаг, хөгжлийн сайдын
2023 оны ... дугаар сарын ... өдрийн .../26
дугаар тушаалтын хоёрдугаар хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

Хүснэгт 1. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө

Хүснэгт 2. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур узүүлэлт, зорилтот тувшин

Монгол Улсын Шадар сайд бөгөөд
 Эдийн засаг, хөгжлийн сайдын,
 2023 оны 08 дугаар сарын 08 өдрийн 26
 дугаар тушаалтын туравдугаар хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЦАГЛАВАР

Хүснэгт 1. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ийн Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах цаглавар

No.	Гүйцэтгэхажил	Хугацаан
1	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах ажлын төлөвлөгөөг тухайн шатны Засаг даргаар батлуулна.	4 сарын 01-ний дотор
2	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хурээнд аймаг, нийслэлийн ЗДТГ нь нөхцөл байдлын дун шинжилгээ хийнэ.	4 сарын 10-ны дотор
3	Холбогдох байгууллагаас санал авах маягт, маягтыг бөглөх заавар (удирдамж)-ыг хүргүүлэх	4 сарын 15-ны дотор
4	Холбогдох байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хурээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэгтгэн боловсруулж, Аймаг, нийслэлийн ЗДТГ-т ирүүлнэ.	6 сарын 01-ний дотор
5	Аймаг, нийслэлийн ЗДТГ нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулна.	7 сарын 05-ны дотор
6	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг ЭЗХЯ-д санал авахаар хүргүүлэх	7 сарын 27-ны дотор
7	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллагад танилцуулж, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал авах	8 сарын 05-ны дотор
8	ЭЗХЯ-наас ирүүлсэн саналыг Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгах	8 сарын 15-ны дотор
9	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг тухайн шатны Засаг даргад танилцуулах	8 сарын 20-ний дотор
10	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэх	8 сарын 25-ний дотор
11	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Нутгийн өөрөө удирдах байгууллагад өргөн мэдүүлэх	09 сарын 01-ний дотор

Монгол Улсын Шадар сайд бөгөөд
 Эдийн засаг, хөгжлийн сайдын
 2023 оны 05 дугаар сарын 08-өдрийн 26.
 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД САНАЛ АВАХ ХҮСНЭГТ

Бодлогын үндэслэл	Үндсэн үйл ажиллагаа, төсөлд арга хэмжээ	Шалгуур, үзүүлэлт	Хэмжих нэгж	Сурье түвшин	Зорилтолтушин	Санхүүжилт, сая, төгрөг	Санхүүжилтийн эх уусварийн залгамжилалт	Хариуцагч	Тайлбар үндэслэл

Тайлбар: Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн саналуудын тайлбар үндэслэл хэсэгт дараах утга агуулга бүхий тайлбарыг бичиж ирүүлнэ үү.

1. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгах хэрэгцээ, шаардлага, төслийн одоогийн явц, гол хийгдэх ажил, хүлээгдэж буй үр дүнгийн талаар бичнэ.
2. Тухайн арга хэмжээг тусгах болсон хэрэгцээ, шаардлагыг тодорхойлон бичнэ.
3. Тухайн арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэмд үзүүлэх эерэг нөлөө /Тухайлбал, шинээр бий болох ажлын байр, эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдэд үзүүлэх нөлөө гэх мэт/
4. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгагдах арга хэмжээ нь он дамжин хэрэгжиж байгаа бол өнөөгийн байдлаар хэрэгжилтийн явц ямар байгаа талаар товч танилцуулга;
5. Зорилтолтушинг тодорхойлсон үндэслэл, гаргасан тооцоо судалгааны талаар товч тайлбар.

Сайхантамир Пүрэвээ

From: Нямцэцэг Гантулга
Sent: Monday, May 8, 2023 2:08 PM
To: Сайхантамир Пүрэвээ
Cc: Нямцэцэг Гантулга
Subject: МУ-ын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танаа - Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал
Attachments: Нямцэцэг Гантулга-2023-05-08T06_07_08.8611574Z_Түvdэндорж Гантэмэр.pdf
Importance: Low

Албан бичгийн төслийн хяналтын карт

Төслийн холбоос:

<https://nda6098177.sharepoint.com/:w/s/MED/docs/EfuC01FLRe9Ju3BTxKdm2noBWu6nSFvncmEB6hA5YqYkUw>

Хаана, хэнд: МУ-ын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танаа

Товч агуулга: Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал

Баталгаажуулсан албан тушаалтнууд:

Мөнгөнсүх Батчулуун 5/4/2023 6:11 PM
Одончимэг Отгон 5/4/2023 9:05 PM
Дашпүрэв Буриад 5/5/2023 8:50 AM
Мөнгөнсүх Батчулуун 5/8/2023 2:02 PM
Одончимэг Отгон 5/5/2023 7:02 PM
Дашпүрэв Буриад 5/8/2023 10:54 AM
Түvdэндорж Гантэмэр 5/8/2023 2:07 PM